# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2020-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

***Төлөвлөгөө баталсан:*** ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

*Аймгийн Засаг дарга* *Г.Батзам*

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*2021 оны 01 дүгээр сарын 02 -ний өдөр*

***Төлөвлөгөө боловсруулсан:***

*Боловсрол, соёл урлагийн газрын дарга* *А.Зургаанжин*

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*2021 оны ..... дүгээр сарын ..... -ний өдөр*

**Боловсрол, соёл, урлагийн газрын стратеги төлөвлөгөөний бүрдэл**

***1. Байгууллагын мандат;***

***2. Алсын хараа;***

***3. Эрхэм зорилго;***

***4. Орчны шинжилгээ;***

## 1. БАЙГУУЛЛАГЫН МАНДАТ

1. Салбарын хууль

-Боловсролын хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль, Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай хууль

2. Төрийн үйлчилгээг иргэнд хүргэх хууль тогтоомж

-Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Зөрчлийн тухай хууль, ТОНӨХБҮХА тухай хууль, Жендэрийн тэгш байдлыг хангах хууль, Шилэн дансны хууль, ЗЗНДНТУТхууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Авлигатай тэмцэх тухай хууль, Төрийн албан ёсны хэлний тухай хууль, Гамшгийн тухай хууль,

3.Төрийн бодлогын хүрээнд

- "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого, ЮНЕСКО –ийн Инчеоны тунхаглал 2030, Боловсролын мастер төлөвлөгөө -2030, Боловсролын дунд

хугацааны төлөвлөгөө-2030, Алсын хараа-2050, МУЗГ-ын 2021-2025 оны НЭЗҮЧ, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газар 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Боловсролын салбарын төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024 он,

3. Боловсролын салбарын үндэсний хөтөлбөрүүд

Хүүхдийн хөгжил хамгааллын хөтөлбөр, Бага насны хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлэх хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн боловсрол хөтөлбөр, Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр, Монгол бичгийн үндэсний хөтөлбөр –III, Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр, Соёл биет бус өв үндэсний хөтөлбөр , Чулуун соёлын өв, Баримтат соёлын өв, Монгол бичгийн үндэсний хөтөлбөр –III,"Сонгодог урлаг-2" үндэсний хөтөлбөр

4.Орон нутгийн бодлогын бичиг баримт

Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,

Аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

**Мандатын шинжилгээний хүснэгт**

| | | |
|---|---|---|
| Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо | | 19 |
| Үүнээс | Тухайн салбарын хуулийн тоо | 11 |
| | Нийтлэг мөрддөг хуулийн тоо | 12 |

| Ерөнхий чиг үүрэг:-1 ***Боловсролын хууль,*** | | |
|---|---|---|
| Үндсэн чиг үүрэг | Дэд чиг үүрэг | Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг |
| ҮЧҮ-1 Сургуулийн өмнөх боловсрол | Яслид 1-2 насны хүүхдийг хамруулах | Бүх шатны ЗД, |
| | СӨБ-3-5 насны хүүхдийг хамруулах | |
| | СӨБ-д 5 настай хүүхдийг бүрэн хамруулах | |
| ҮЧҮ-2 Бага боловсрол | 6-8 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулах | Бүх шатны ЗД, |
| | Эх хэлний чадамжтай, сурах арга барил эзэмшүүлнэ. | |
| | | |
| ҮЧҮ-3 Суурь, бүрэн дунд боловсрол | Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадамж эзэмшүүлэх | Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Уул уурхайн жишиг Полетехникийн коллеж, БҮТ, |
| | Мэргэжлийн чиг баримжаа олгох | |

| | | |
|---|---|---|
| ҮЧҮ-4 Боловсролын салбарын үндэсний хөтөлбөрүүд | Тогтвортой хөгжлийн боловсрол хөтөлбөр | Байгаль орчин мэдээлэл сурталчилгааны төв. |
| | "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх | |
| | "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III" | |
| | Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр, | |
| | Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр, | |
| Ерөнхий чиг үүрэг-2 ***Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль,*** | | |
| ҮЧҮ-1 Хүүхэд хамгааллын бодлого, | Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал | Хөдөлмөр,халамж үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, ДЗ Бор-Өндөр ОНХХ, |
| | Бүх орчинд хүүхдийн эрх хангагдах | |
| | Хүүхэд харах үйлчилгээнд 2-3 насны хүүхдийг хамруулна. | |
| | Боловсролын байгууллагын орчинд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх | |
| Ерөнхий чиг үүрэг-3 ***Төсвийн тухай хууль*** | | |
| ҮЧҮ-1 ЕБС-ийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний хууль, | Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэх | ХХААХҮГ<br>МХГ |
| | Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээнд ажиллах, мэргэжлийн хүний нөөцийн орон тоог нэмэгдүүлэх | |
| | Сургууль, цэцэрлэгийн төсвийн төслийг, хуулийн хугацаанд хянах | БСШУ-ны яамны төсвийн бодлогын газар, ЕБС-иуд, |

| | | |
|---|---|---|
| | | цэцэрлэгүүд |
| ҮЧҮ-2 Тухайн жилийн төсвийн төслийг хянуулах, төсвийн хуваарилалт, ЗЗНДНТУТхууль,ТОНӨХБ ҮХАТ хууль, | Сургууль, цэцэрлэгийн батлагдсан төсвийг оновчтой хуваарилах | Аймгийн ЗДТГ, СТСХ |
| | Байгууллагын батлагдсан төсвийг зарцуулах, тайлагнах | |
| Шилэн дансны хууль, | Шилэн дансны мэдээлийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээллэх | БСУГ |
| Ерөнхий чиг үүрэг-4 ***Соёлын тухай хууль*** | | |
| ҮЧҮ-1 Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ | Боржигин түмний өв соёлыг түгээн дэлгэрүүлж, залуу үед өвлүүлэх, сурталчлан таниулах олон талт арга хэмжээг зохион байгуулах | АЗДТГ, БСУГ, СУБ-ууд |
| | Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах | АЗДТГ, БСУГ, СУБ-ууд |
| | Соёл, урлагийн арга хэмжээг хэрэгжүүлэх | АЗДТГ, БСУГ, СУБ-ууд |
| | Эх хэл, бичиг үсэг, түүх, соёлын мэдлэгийг гүнзгийрүүлэх, уран сайхан, гоо зүйн хүмүүжил олгох | АЗДТГ, БСУГ, СУБ-ууд |
| | Бүх нийтийн соёл, урлагийн боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлын тоо | АЗДТГ, БСУГ, СУБ-ууд |
| | Үндэсний, сонгодог, орчин үеийн урлагийн төрлүүдийг жигд хөгжүүлж, хүн амд урлаг гоо зүйн боловсрол олгох | АЗДТГ, БСУГ,Боржигин чуулга |
| | Соёл урлагийн байгууллагуудын орчин, нөхцөлийг сайжруулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах | Соёлын яам, АЗДТГ, БСУГ, СУБ-ууд |
| ҮЧҮ-2 Номын сангийн хууль | Эрдэм шинжилгээ, судалгаа, мэдээллийн төв болох | Нийтийн номын сан, Соёлын төвийн номын сан |
| | Орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг баяжуулах, орон нутгийн иргэнийг номын сангийн үйлчилгээнд өргөн хамруулах арга хэмжээг зохион байгуулах | АЗДТГ, БСУГ,Нийтийн номын сан |

| | | |
|---|---|---|
| | Стандартад нийцсэн номын сангийн үйлчилгээг уншигчид үзүүлэх, уншлагын үйлчилгээг хүргэх; | Нийтийн номын сан, Соёлын төвийн номын сан |
| ҮЧҮ-3 Соёлын өвийг хамгаалах тухай хууль | Соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх, бүртгэн баримтжуулах, олон нийтэд таниулах, | Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Сум аймгийн засаг дарга<br><br>Боржигин өв музей, Соёлын төвүүд |
| | Нутаг дэвсгэртээ соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, шаардлагатай төсөв хөрөнгийг баталж, хяналт тавих; | Боржигин өв музей Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,<br><br>Сум аймгийн засаг дарга нар |
| | Соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, Соёлын биет бус өв өвлөн уламжлагчдын шавь сургалт явуулах, алдаршуулан урамшууулах хуульд заасан дэмжлэг үзүүлэх; | Боржигин өв музей Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Сум, аймгийн засаг дарга нар |
| Музейн тухай хууль | Соёлын өвийн талаарх мэдлэг олгох, түүнийг хамгаалах, сурталчлах арга хэмжээг гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлал болон боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлэх | Боржигин өв музей<br><br>Соёлын төвүүд |
| | Музей нь үзмэр, цуглуулгыг эргэлтэд оруулах, мэдлэг мэдээлэл түгээх, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх зорилгоор үзүүллэгийг тасралтгүй шинэчлэн дэглэх зарчим баримтлана. | Боржигин өв музей<br><br>Соёлын төвүүд |
| | Соёлын өвийг бүртгэх, цуглуулах соёлын үнэт зүйлийг эрэн сурвалжлах, нээж илрүүлэх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, боловсрол танин мэдэхүйн ажил зохион байгуулах | Боржигин өв музей<br><br>Соёлын төвүүд |

## 2. АЛСЫН ХАРАА

Орон нутгийн онцлогт тохирсон боловсрол, соёлын оновчтой бодлогыг хэрэгжүүлэн, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлж, үндэсний өв, соёл, ёс уламжлалаа дээдэлсэн иргэн төлөвшүүлнэ.

## 3. ЭРХЭМ ЗОРИЛГО

Оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино

## 4.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

***Орчны шинжилгээний үр дүнг нэгтгэх SWOT хүснэгт /БОЛОВСРОЛ/***

Зорилт:СӨБ -ын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

| | Давуу тал | Сул тал |
|---|---|---|
| [illegible] | • Барилга байгууламж нэмэгдэж байна<br>• Хүүхэд бүрийн хөгжилд ахиц гарч байна<br>• Эрүүл ахуйн шаардлага хангаж ажилладаг<br>• Багшийн эрүүл мэнд анхаарч ажилладаг. | • Байр багтаамж муу,багшийн ачаалал их<br>• 1 бүлэг хэт олон хүүхэдтэй, I хүүхдэд оногдох хувьсах зардал бага<br>• Нэг хүүхдэд ногдох талбай, агаарын хэмжээ хүрэлцэхгүй |
| [illegible] | Боломж | Бэрхшээл |

| | |
|---|---|
| • Хамран сургах тойргийн хүүхдийг бүртгэж хамруулах<br>• Хаягын бүртгэлийг цэгцлэх,гадаад оронд явсан хүүхдийг хасаж тооцох | • Цэцэрлэг бүр харилцан адилгүй<br>• 1 хүүхдэд ногдох хувьсах зардал цалинд хүрэлцэхгүй |

Зорилт: Бага боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг тэгш хангана.

| Давуу тал | Сул тал |
|---|---|
| • Багш бүр жигд, тэгш хөгжих боломжтой<br>• Дэд бүтэц /зам тээвэр харилцаа холбоо/ маш сайн<br>• Эцэг эх хүүхдийнхээ боловсролд анхаардаг /малчин өрхийн тоо цөөн/<br>• Суралцагчдын тоо цөөн хүрч ажиллах боломжтой.<br>• Зорилтот бүлгийн хүүхдээ дэмжих орчин сайн. | • Багшлах боловсон хүчний дутагдалтай<br>• Эрсдэлд өртөх магадлал өндөр<br>• Эцэг эхчүүд, боловсролыг үнэлэх үнэлэмж муу.<br>• ХБХ-тэй тулж ажиллах туршлага, дутмаг, мэргэшээгүй<br>• Сургуулийн барилга чанар муудсан. |
| **Боломж** | **Бэрхшээл** |
| • Орон нутагт дутагдалтай мэргэжлийн багшийг бодлогоор дэмжих<br>• Хамтын ажиллагаанд түшиглэх<br>• Эцэг эхийн хандлагыг өөрчлөх<br>• Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, ажиллах чадварыг ажлын байран дээр хөгжүүлэх | • Багш бэлтгэх тогтолцооны бодлого алдагдах<br>• Ажлын байр цөөн, амжиргааны түвшин доогуур<br>• Монголчуудын амьдралын онцлог /хүүхэдтэйгээ ойр байж хэтийн зорилгыг нь ухааруулдаггүй/<br>• Насан туршдаа боловсрох,цаг ямагт хөгжих хэрэгцээг ойлгохгүй |
| | |

Зорилт: Суурь ,ахлах боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг тэгш хангана.

| Давуу тал | Сул тал |
|---|---|
| • Анги дүүргэлт<br>• Боловсон хүчин (хангалт)<br>• Хамтын ажиллагаа<br>• ЭНШ –ын НУ,МХ-ийн хичээлийн гүйцэтгэл<br>• Хүүхдийн тоо цөөн,эцэг эхийн амьдралын боломж сайн | • Сурах бичиг<br>• Чадварлаг багш хомс<br>• Сургалтын орчин<br>• Сэтгэл зүйч<br>• Мэргэжил сонголт(оновчгүй)<br>• Мэргэжилтэн дутмаг |

| Боломж | Бэрхшээл |
| --- | --- |
| • Дэд бүтэц<br>• Амьдрах орчин<br>• Шинэ барилга<br>• Их дээд сургуулийн хуваарь хангалттай<br>• Дэд бүтэц хөгжсөн<br>• Мэргэжил дээшлүүлэх<br>• Харилцаа холбоо хөгжсөн<br>• Байр сууц (амьдрах орчин сайн) | • Эцэг эхийн хариуцлага сул<br>• Дотуур байрны хүрэлцээ<br>• Амьдралын түвшин<br>• Хүүхэд хөгжлийн ордон<br>• Сургалтын төв<br>• Сурагчид аймгийн төвд суралцах сонирхолтой<br>• Суралцагч өөрсдийн чадвараа хөгжүүлэх орчин тун бага<br>• Стандарт сул хичээлийн байртай |

Зорилт: Хүүхэд хамгааллын бодлого,

| Давуу тал | Сул тал |
| --- | --- |
| • Тусламж дэмжлэг<br>• Оролцооны бүлгээр дамжуулан хүүхэд хүүхэддээ чөлөөлж байна<br>• Хүүхдийн хамтын ажиллагаа сайн<br>• Мэргэжлийн нийгмийн ажилтнаар хангагдсан. | • Суурь судалгаа үнэн зөв гарахгүй байна<br>• Тэгш хамруулах боловсролын орчин бүрдээгүй<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах туршлагагүй<br>• Сэтгэл зүйч<br>• Хүүхэдтэй ганцаарчилж уулзах танхим<br>• Хувь хүний нөөц хадгалагдахгүй<br>• Хүүхэд хөгжүүлэх газар байхгүй |
| **Боломж** | **Бэрхшээл** |
| ○ Хамтран ажиллах байгууллага<br>• Залуу багш хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцаж байна /О/Б/<br>○ Бие дааж суралцах<br>○ Санаачлага | ○ Эцэг эхийн оролцоо сул<br>○ Харилцаа хандлага сул<br>○ Мэдээлэлд ач холбогдол өгдөггүй /Х.Х/ |

***Орчны шинжилгээний үр дүнг нэгтгэх SWOT хүснэгт /СОЁЛ УРЛАГ/***

***Зорилт: 1*** Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх

| Давуу тал | Сул тал |
|---|---|
| ✓ Говьсүмбэр аймаг болон зэргэлдээ аймаг сумын хүн амд аялан тоглолтоор Боржигин өв соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг идэвхитэй явуулж, улс, бүсийн уралдаан тэмцээнд амжилттай оролцож байна.<br>✓ Аймагтаа ганц үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн урлагийн байгууллага тул улс бүсийн хэмжээнд өрсөлдөх, бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх бүрэн боломжтой.<br>✓ Уран бүтээлч, ажилтнуудын дийлэнхи нь залуучууд байгаа нь цаашид байгууллагын өрсөлдөх чадварт эерэг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдсэн. | ✓ Стандартын шаардлага хангасан барилга байгууламжгүй<br>✓ Төсвөөс тодорхой хэмжээний санхүүжилт авдаг боловч хүрэлцдэггүй, нэмэлт санхүүжилт бүрдүүлэх боломж эрх зүйн хувьд хязгаардмал учраас үйл ажиллагааны хөрвөх боломжийг хязгаарлах, зах зээлд өрсөлдөхөд хүндрэл учирдаг.<br>✓ Тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах<br>✓ Иргэд үйлчилүүлэгчдийн |
| **Боломж** | **Бэрхшээл** |
| ✓ Төрөөс сүүлийн жилүүдэд соёл урлагийн байгууллагуудыг анхаарч, дэмжлэг үзүүлж эхэлж байгаа нь хөгжих таатай боломж бүрдэж байна.<br>✓ Орон нутгийн удирдлага чуулгын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажилладаг.<br>✓ Боржигин өв соёлын өлгий нутагт байгаа нь өөрийн онцлог бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, өрсөлдөх боломж байна.<br>✓ Хүн амын урлагийн эрэлт нэмэгдэх хандлагатай, хүүхэд, залуучууд урлагийн боловсрол авах сонирхолтой байгаа нь театр үйл ажиллагаагаа өргөжүүлэх нөхцөл бүрдэж байна. | ✓ Аймгийн зам харилцаа, дэд бүтэц сайн хөгжсөн боловч хүн ам хэт цөөн байгаа нь үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөжүүлэхэд хүндрэлтэй.<br>✓ Хүн амын амьжиргааны түвшин доогуур байгаа нь үзвэр үзэх давтамж цөөн байх шалтгаан болж байна. |

***Зорилт: 2*** Номын сангийн хуулийг хэрэгжүүлэх

| Давуу тал | Сул тал |
|---|---|

| | Сул тал: |
|---|---|
| 1. Үйл ажиллагаа тогтмолжсон<br>2. Ажиллах, туршлага дадал бүхий мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан<br>3. Номын сангийн LIB-4 цогц программ хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, үйлчилгээг автоматжуулан, электрон каталогийг бий болгосон<br>4. Монголын болон Дэлхийн шилдэг зохиол бүтээлээс бүрдсэн өргөн сонголт бүхий 9000 гаруй номын фондтой<br>5. - Төрийн болон төрийн бус байгууллагууд, зохиолч, уран бүтээлчидтэй хамтран ажилладаг | - Номын сангийн зориулалтын стандартын байргүй<br><br>- Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5742:2019 стандартын шаардлагад нийцсэн үйлчилгээний төрөлжсөн зориулалтын танхимууд байхгүй<br><br>- Сан хөмрөгийн баяжилт хийхэд төсөв бага<br><br>- Ном хэвлэлийг бүрэн болон хэсэгчилсэн цахим уншлагын үйлчилгээнд оруулах боломжгүй |
| **Боломж** | **Бэрхшээл** |
| 1. Мэдээллийн технологид суурилсан Номын сангийн цахим үйлчилгээг өргөжүүлэх:<br>2. Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх:<br>3. Улсын болон бусад аймгийн номын сангийн хамтын ажиллагааны уламжлалыг нэвтрүүлэх<br>4. Иргэдийн гар дээрхи ганц хувь бүтээл, гар бичмэл, ховор ном судрыг сурьалжлан олох | 1. Байгууллагын тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн боловсон хүчний шилжилт хөдөлгөөн /шилжих, тэтгэвэрт гарах гэх мэт/<br>2. Хүний нөөцийн хөгжил, бүтээлч санаачлага сулрах<br>3. Давтагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл, нийгэм, эдийн засаг, улс төрөөс шаттаалан удирдлага, зохион байгуулалтын өөрчлөлт<br>4. Техник технологийн үсрэнгүй хөгжлийн хоцрогдол<br>5. - Байгалийн гамшиг, сүйрэл, хүний гоц халдварт өвчний хорио, цээр |

***Зорилт: 3*** Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх

| **Давуу тал** | **Сул тал** |
|---|---|
| 1. Мэргэжлийн боловсон хүчинтэй<br>2. Албан хаагчдын нийгмийн баталгааг сайн хангадаг<br>3. Техник хангамжийн хангалт сайн<br>4. Хүн амын дунд мэдээлэл хүргэлт түгээлт сайн<br>5. Залуу боловсон хүчинтэй<br>6. Сургалтын хэрэглэгдэхүүн сайн<br>7. Ажлын хуваарлалт сайн<br>8. Удирдлага зохион байгуулалт сайн | 1. Зориулалтын барилгагүй<br>2. Үзмэр баяжуулах төсөв санхүү дутмаг<br>3. Барилга байгууламжийн зай талбай бага, боловсролын сургалт явуулах зай талбай бага<br>4. Орон тоо дутмаг<br>5. Ажлын давхцал, ачаалал их<br>6. Гамшгийн үед ажиллах ур чадвар муу<br>7. Орон нутгийн хүмүүсийг танихгүй<br>8. Хүнд ажлаа ойлгуулах чадвар муу |

| | |
|---|---|
| 9. Ажилчдын харилцаа хандлага сайн<br>10. Цахимд ажиллах ур чадвар сайн<br>11. Сургалт явуулах ур чадвар сайн<br>12. Баримт бичиг боловсруулалт сайн<br>13. Ажлын байранд хөрвөх чадвар сайн<br>14. Багаар ажиллах чадвар сайн | 9. Орон нутгийн талаар мэдлэг, мэдээлэл муу<br>10. Мэдээлэл солилцох тал дээр дутмаг<br>11. Ажлын туршлага дутмаг<br>12. Үзмэрийн баяжилт цөөхөн<br>13. Судалгааны арга барил, арга зүй тааруу , судалгааны ажил хийдэггүй<br>14. Хүний нөөц тогтворгүй Мэргэжлийн хүний нөөц аймагт дутмаг<br>15. Мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдалт муу |
| **Боломж** | **Бэрхшээл** |
| 1. Боржигин судлалын төв музей болон хөгжих боломжтой<br>2. Шинээр байрны зураг төсөл хийгдэж байна<br>3. Аймаг орон нутгийн дэмжлэгийг авах боломжтой<br>4. Салбарт хэрэгждэг хууль тогтоомж, дүрэм журам ихтэй<br>5. Цөөхөн хүн амтай<br>6. Боржигин 17 сумдаар явж судалгаа хийх, үйл ажиллагаандаа татан оролцуулах боломжтой<br>7. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой<br>8. Дэд бүтэц сайтай.<br>9. Сургууль, цэцэрлэг цөөн<br>10. Туршлага судлах боломжтой | 1. Гал түймэр, газар хөдлөлтийн эрсдэлтэй<br>2. Стандартын барилга байхгүйгээс үзмэрийн хадгалалтанд сөргөөр нөлөөлөх<br>3. Унаагүй учир үл хөдлөх дурсгалд хяналт тавих боломж муу байгаагаас хууль бус малтлага гарах |

***Зорилт: 4*** Музейн тухай хуулийг хэрэгжүүлэх

| Давуу тал | Сул тал |
|---|---|
| 1.Бүртгэн баримтжуулалт сайн<br>2.Үзэсгэлэн дэглэх боломжтой<br>3.Сургалтын хэрэглэгдэхүүн сайн<br>4.Сургалт явуулах хүний нөөцтэй<br>5.Сургалт явуулах ур чадвартай<br>6.Хүүхэд үнэ төлбөргүй үзүүлж байгаа | 1. Үзмэрийн цуглуулга, дэглэлтийн үзэл баримтлал байхгүй<br>2. Үзмэрийн үзүүлэг дэглэлтийн төлөвлөгөө байхгүй<br>3. Сургалт явуулах тоног төхөөрөмж техник хэрэгсэл дутмаг, ширээ сандал байхгүй,<br>4. Судалгаа хийх зардал бага<br>5. Судалгааны эмхэтгэл ном, гаргах санхүүжилт байхгүй<br>6. Мэргэжил арга зүй муу байдаг<br>7. Үзмэр дэглэн шинэчлэхэд үзмэрийн тоо цөөн<br>8. Хүүхэд музей үзэхэд багтаамж бага |

| | |
|---|---|
| 7.Үнэ төлбөрийн тариф өөрсдөө тогтоох боломж нөхцөл бүрдсэн<br><br>8.Мэргэжлийн хүний нөөцтэй<br><br>9.Үзмэрийг бүртгэн баримтжуулах программтай<br><br>10.Боржигин сумдуудад судалгаа хийх судлагдахуунтай<br><br>11.ЭШХурал жил бүр хийж эмхтгэл сэтгүүл, DVD гаргасан<br><br>12.Байгууллагад судалгааны ном, гарын авлагатай | 9. Орон тоо хүрэлцэхгүй дутмаг<br>10. Сургалт явуулах орчин муу<br>11. Албан хаагчдад соёлын өвийг бүртгэн баримтжуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл дутагдалтай / Дрон, JPS, зургийн аппарат, камер, лазэр метр, бусад хэмжигчүүд /,<br>12. Сан хөмрөгийн стандартын тавиур байхгүй<br>13. Хүний нөөцийг сургах, давтан сургалтанд хамруулах, мэргэшүүлэх шаардлагатай<br>14. Боловсролын ажлыг ЕБС хичээлүүдийн хөтөлбөрт оруулан уялдуулах, хамтын ажиллагааг сайжруулах<br>15. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд музей тайлбарлах ур чадвар тааруу<br><br>Дохиоллын систем / ус мэдрэгч, хөдөлгөөн мэдрэгч, утаа мэдрэгч / ажиллагаагүй болсон тул гал, гамшгийн үед урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмжгүй |
| **Боломж** | **Бэрхшээл** |
| Соёлын үйлдвэрлэл бүтээгдэхүүн бий болгох, худалдан борлуулах<br><br>2.Үзмэртэй шууд харьцах албан хаагчдад 8 жил тутам 1 жилийн цалин өгч нийгмийн асуудалд дэмжсэн.<br><br>3.Иргэдийн гар дээрх үзмэрийг нээж илрүүлэх боломтой<br><br>4.Хүн ам цөөтэй, газар нутгийн хэмжээ бага учраас нийт хүн амын 80% хүрэх боломжтой<br><br>5.Соёлын өвийн боловсролыг ЕБС-ийн хичээлийн цөм хөтөлбөрт тусгах<br><br>6.Орон нутгийн судлаачид, Боржигин судлалаар мэргэшсэн эрдэмтэн судлаачид, 7.Боржигин сумдын удирдлагуудтай хамтарч ажилладаг<br><br>8.Боржигин овогтон холбоо ТББ аймагт байгуулагдсан<br><br>9.Иргэдийн гар дээр хадгалагдаж байгаа соёлын үнэт үйлсээр үзэсгэлэн гаргах<br><br>10 . Музейн хайгуул, малтлага судалгааны | 1.Стандартын байргүй улмаас тусгай зөвшөөрөл цуцлах магадлал өндөр<br><br>2.Сан хөмрөгийн өрөө жижиг учраас үзмэрийн онцлог шинж хадгалалтын нөхцөл байдлыг харгалзан төрөлжүүлээгүйгээс үзмэр гэмтэх аюултай<br><br>3.Шатахуун түгээгүүр, тэсэрч дэлбэрэх, дэгдэмхий бодис хадгалах барилга байгууламжаас 1000 метрийн дотор музейн барилга байна.<br><br>4.Боловсролын танхим байхгүй, ширээ сандал огт байхгүйгээс сургалт явуулах орчин муу<br><br>5.Иргэдийн гар дээрх үнэ цэнэтэй өв үзмэр худалдан авах зардал байхгүй<br><br>6.Музейд вертуаль, AR техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэхэд санхүүг аймгийн төсөв тусгах<br><br>7.Соёлын өвийг эрэн сурвалжлах, нээн илрүүлэх, бүртгэн баримтжуулах, эрдэм шинжилгээ судалгаа хийхэд машин, байхгүй. |

| | |
|---|---|
| ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хийх | 8.Сүмбэр сумын бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажилтан байхгүй.<br><br>9. Сургалт зардал хүрдэггүй, уралдаан тэмцээн зардал байхгүй |

## 5. БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ



**БОЛОВСРОЛ СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ОРОН ТОО**

| № | Албан тушаалын нэр | Орон тоо | Албан тушаалын ангилал, зэрэглэл |
|---|---|---|---|
| **ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛ** | | | |
| 1 | Дарга | 1 | ТЗ-9 |
| 2 | Ахлах мэргэжилтэн | 1 | ТЗ-6 |
| 3 | Математик, статистак хариуцсан мэргэжилтэн | 1 | ТЗ-5 |
| 4 | Хүмүүнлэгийн ухаан хариуцсан мэргэжилтэн | 1 | ТЗ-5 |
| 5 | СӨБ хариуцсан мэргэжилтэн | 1 | ТЗ-5 |
| 6 | Соёл урлаг хариуцсан мэргэжилтэн | 1 | ТЗ-5 |
| **ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛ** | | | |
| 11 | | | |
| 12 | Архив, бичиг хэргийн ажилтан | 1 | ТҮ-5 |
| **ГЭРЭЭТ** | | | |
| 17 | Жолооч | 1 | |
| | Үйлчлэгч | 1 | |

ЗУРАГЛАЛ / бүдүүвч /

*2020-2024 ОНД ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ*

## СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

/ Говьсүмбэр аймгийн Боловсрол соёл урлагийн газар /

/ 2021 – 2024 ОН /

| Засгийн газрын ... тусгагдсан үндсэн чиг үүрэг хэрэгжүүлэх зорилт | Стратеги /арга, зам/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Санхүүгийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|
| Ерөнхий чиг үүргийн нэр: **Боловсролын хууль** | | | | | |
| Зорилт-1"Боловсролыг дэмжих арга хэмжээ"-г хэрэгжүүлнэ. | 1."Боловсролыг дэмжих арга хэмжээ"-г хэрэгжүүлнэ. | Боловсролыг дэмжих арга хэмжээ 100% хэрэгжинэ.Санхүүжилт нэмэгдсэн байна. | Ковид-19 цар тахлын үед арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй. | Боловсролыг дэмжих арга хэмжээ 100% хэрэгжинэ.Санхүүжилт нэмэгдсэн байна. | Орон нутгийн төсөв |
| Зорилт -2 Суралцагчда ээлтэй сургалтын орчны бүрдүүлж, хүртээмжи нэмэгдүүлэх, тусга хэрэгцээт хүүхдийг ердий сургууль, цэцэрлэгт сура хөгжих боломжи бүрдүүлнэ | 1.Шивээговь сумын 3 дугаар сургууль, Сүмбэр сумын 2 дугаар сургуулиудын шинэ барилга, 2 дугаар сургуулийн дотуур байрны засвар, 1,5 дугаар сургуулийн өргөтгөл, 3,6 дугаар цэцэрлэгийн өргөтгөл,3,5 дугаар цэцэрлэгийн их засвар, 4 дүгээр сургууль,цэцэрлэгийн шинэ барилгын зураг хийнэ | Сургууль,цэцэрлэг бүр сургалтын таатай орчин бүрдүүлнэ. | 2 дугаар сургуулийн барилга, 5 дугаар цэцэрлэгийн 2 өргөтгөл дууснa.3 дугаар сургуулийн барилга эхэлнэ.3 дугаар цэцэрлэгийн өртгөлийн зураг хийгдсэн. | 2 дугаар сургуулийн дотуур байрны засвар хийгдэж, 1,5 дугаар сургуулийн өргөтгөл баригдаж, 3,6 дугаар цэцэрлэгийн өргөтгөл баригдаж,3,5 дугаар цэцэрлэгийн их засвар хийгдэнэ, 4 дүгээр сургууль,цэцэрлэгийн шинэ барилгын зураг хийгдсэн байна. | Улсын болон орон нутгийн төсөв |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Зорилт -3 Сургуулиудын МХТ –ын орчин нөхцлийг сайжруулах | 1,2,5 дугаар сургуулийн Мэдээлэл зүйн кабинетийг шинэчлэх | Мэдээлэл зүйн 3 танхим шинэчлэнэ. | 1,2,5 дугаар сургуулийн МХТ –ын танхим Компьютер гүй хүүхэд хичээллэх боломцоог үй | Мэдээлэл зүйн 3 танхим шинэчлэнэ. | Улсын болон орон нутгийн төсөв |
| Үндсэн чиг үүргийн нэр: Сургуулийн өмнөх боловсрол | | | | | |
| Зорилт – СӨБ -ын хамран сургалтыг нэмэгдүүлнэ | 1 Яслид 1-2 насны хүүхдийг,хамруулах | Яслид хамрагдах хүүхдийн тоо | 0 | 75 | Улсын төсөв |
| | 2. СӨБ -д хамрагдах хүүхдийн насыг 3-5 нас болгож, хамралтыг нэмэгдүүлнэ. | СӨБ –д хамрагдалтын хувь | 97,8 | 98 | Улсын төсөв |
| | 3. 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана. | 5 настай хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт | 97,1 | 100 | Улсын төсөв |
| | 4.Хүүхэд харах үйлчилгээ | Хамрагдсан хүүхдийн тоо | 5 | 15 | Улсын төсөв |
| Үндсэн чиг үүргийн нэр: *Бага, суурь, бүрэн дунд боловсрол* | | | | | |
| Зорилт – 1 Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг тэгш хангана. | 6-8 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулах | Бага боловсролын хамран сургалтын хувь | 100 | 100 | Улсын төсөв |
| | Эх хэлний чадамжтай, сурах арга барил эзэмшүүлнэ. | Унших бичих чадвар | 38 | 50 | Улсын төсөв |
| | Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадамж эзэмшүүлэх Хөндлөнгийн үнэлгээ | Чанарын үнэлгээний үзүүлэлт /Улсад/ | 37 | 40 | Улсын төсөв |
| | Мэргэжлийн чиг баримжаа олгох ЭНШ | Улс, аймгийн дундаж үнэлгээний ахиц | 510 | 515 | Улсын төсөв |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Боржигон өв орон нутгийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Боржигин өв, соёлыг өвлүүлэн хөгжүүлэх 2 хөтөлберийг хэвлэх, сургууль, цэцэрлэгт сургалтанд нэвтрүүлэх | 2 | 2 | Орон нутгийн төсөв |
| | ЕБСургалтын чанарыг олон улсын PISA үнэлгээнд хамрагдаж, үнэлгээний арга зүйд суралцана._ | Үнэлгээний арга зүйд багш нар суралцаж, дпаалгаврын сантай болно. | 13 багш | 80 багш, 20000 даалгавартай сантай болох | Орон нутгийн төсөв |
| | НТБ-ын төвийг байгуулан, нээлттэй тогтолцоог төлөвшүүлнэ. | НТБ төвтэй болно. | Дүйцсэн хөтөлбөрийг сургууль түшиглэн хэрэгжүүлдэг, 36 хүн хамрагдаж байна. | НТБ төвтэй болно. | Улсын болон орон нутгийн төсөв |
| Зорилт – 2 Боловсролын салбарын үндэсний хөтөлбөрүүд | 1.Тогтвортой хөгжлийн боловсрол хөтөлбөр | Сургууль,цэцэрлэгт тогтмол хэрэгжүүлнэ. | Хөтөлбөр хэрэгжиж байгаа | Сургууль,цэцэрлэгт тогтмол хэрэгжүүлнэ. | Улсын болон орон нутгийн төсөв |
| | 2. “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх | “Чадварлаг багш” хөтөлбөр хэрэгжинэ. | Багш нарыг урамшуулах, дэмжих ?0.0 сай төгрөги | 80 багшийг урамшуулж, дэмжинэ.100 % Багш нарыг сургаж, чадваржуулна. | Улсын болон орон нутгийн төсөв |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | йн төсөв батлагд сан | | |
| | 3. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III" | Иргэдийн монгол бичгийн чадварыг нэмэгдүүлнэ. | Монгол бичгийн хөтөлбөр зөвхөн боловсролын салбарт хэрэгжиж байна. | Иргэд, төрийн албан хаагчдын 75% -д монголд бичиг түгээнэ. | Улсын болон орон нутгийн төсөв |
| | 3. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр, | "Үдийн хоол хөтөлбөр"-ийг сургууль бүрт хэрэгжүүлнэ. | "Үдийн цай" хөтөлбөр хэрэгждэг. | Бүх сургуулийг хоол үйлдвэрлэл явуулах тоног төхөөрөмжөөр хангана. | Улсын болон орон нутгийн төсөв |
| Ерөнхий чиг үүргийн нэр: **Хүүхэд хамгааллын бодлого** | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: *Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль,* | | | | | |
| Зорилт – 1 Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр, Хүүхэд хамгааллын бодлого, | Тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сургах, хөгжих боломжийг бүрдүүлнэ. | Тусгай хэрэгцээт боловсрол олгох орчныг тус бүр 2:2 сургууль,цэцэрлэгт бүрдүүлнэ. Багш нарыг 100% сургана. | ХБХ – ийн 78,6% ийн боловсролд хамруулсан ч орчин бүрдээгүй, багш нар чадваржаагүй. | ХБХ бүрийг боловсролд хамруулна. | Улсын болон орон нутгийн төсөв |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Боловсролын салбарт дахь хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлж, хүүхдийн эрх хангагдах | Цэцэрлэг, сургууль бүрт хүүхэд хамгааллын бодлго хэрэгжүүлнэ. | Хүүхэд хамгааллын бодлоготой ч хэрэгжилт хангалтгүй | Цэцэрлэг, сургуулийн хүүхэд хамгааллын бодлого 100% хэрэгжинэ | Улсын болон орон нутгийн төсөв |
| | Боловсролын байгууллагын орчинд, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх | Хүүхэд эрсдэлд орох нөхцлийг судалж, асуудлыг 100% шийдвэрлэх | Эрсдлийн үнэлгээ хийдэг ч үр дүн багатай | Хүүхэд эрсдэлд орох нөхцлийг судалж, асуудлыг 100% шийдвэрлэх | Улсын болон орон нутгийн төсөв |
| Зорилт-1 Салбарын хэмжээнд өр төлбөргүй ажиллах | 1.Тусгай зориулалтын шилжүүлэгт өр төлбөр үүсгэхгүй байх; | Салбараараа өргүй ажиллах | Сургуулийн цалих төсөв хүрэлцээгүй | Салбараараа Аудитын зөрчилгүй болох | Улсын төсөв |
| Зорилт-2 Санхүүгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлнэ. | 1.Төсөв, санхүүгийн зарцуулалт, гүйцэтгэлийг Шилэн дансны хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээллэх, дотоод аудитын болон хяналтын тогтолцоог хэвийн ажиллуулах; | Салбараараа Аудитын зөрчилгүй болох | Цэцэрлэг, сургуулийн санхүүгийн ажилтнууд туршлагагүйгээс аудитын зөрчил байнга гардаг | Салбараараа Аудитын зөрчилгүй болох | Улсын төсөв |

| | |
|---|---|
| **Ерөнхий чиг үүргийн нэр: Соёлын урлагийн бодлого** | |
| **Үндсэн чиг үүргийн нэр** | Соёлын тухайн хууль, Соёлын өвийн хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Музейн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| : | тухай хууль | | | | |
| | 1.1Боржигин түмний өв соёлыг түгээн дэлгэрүүлж, залуу үед өвлүүлэх, сурталчлан таниулах олон талт арга хэмжээг зохион байгуулах | -Зохион байгуулсан эвент арга хэмжээ тоо-1<br>-Боржигин өв соёлыг сурталчилсан уралдаан тэмцээний тоо | 2019 онд Соёлын биет бус өвийн 5 ай савын хүрээнд зохион байгуулж 5 аймгийн 15 сум хамрагдсан | Эвент тоо-1<br><br>5 аймгийн 17 сум | УТ, АОНХС 90,0 сая төгрөг |
| **Зорилт-1** Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэй | 1.2 Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх тогтолцоог бий болгож, соёлын ажилтан, уран бүтээлчдийн хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, ажил эрхлэлтийг дэмжиж, нийгмийн баталгааг сайжруулна. | -Мэргэжлийн боловсон хүчний хангалт<br>-Мэргэшүүлэх давтсан сургалтанд хамрагдагсадын тоо<br>Хүний нөөц нийгмийн баталгаа хөтөлбөрийг хэрэгжүүлэ | 80%<br><br>20%<br><br>Батлагдсан хөтөлбөр-1 | 90%<br><br>50%<br><br>100% | Орон нутаг, байгууллага, УТөсөв |
| | 1.3 Соёл урлагийн арга хэмжээг хэрэгжүүлэх | Соёл, урлагийн арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр батлаж, хөрөнгө төсөвлөх | Соёл, урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөр-1 | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100% | АОНХС 80,0 сая төгрөг |
| | 1.4 Эх хэл, бичиг үсэг, түүх, соёлын мэдлэгийг гүнзгийрүүлэх, уран сайхан, гоо зүйн хүмүүжил | Байгууллагын албан хаагчдыг түүх, соёл | Зохион байгуулсан | Зохион байгуулсан | Тухайн байгууллагын төсөв, ОНХСан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | олгох | Монгол бичгийн сургалтанд хамруулж, хуучин Монгол бичгээр унших, бичих чадавхийг сайжруулна. | сургалтын тоо-0 Хамрагдсан төрийн албан хаагчдын хувь-30 | сургалтын тоо-10 Хамрагдсан төрийн албан хаагчдын хувь-100 | |
| | 1.5 Бүх нийтийн соёл, урлагийн боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг идэвхжүүлж, үндэсний нэгдмэл үнэт зүйлээр бахархах, эх оронч үзэл, нүүдлийн өв соёлыг таниулан сурталчилах | Бүхийн нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх | Батлагдсан хөтөлбөр-0 | Батлагдсан хөтөлбөр-1 | УТ,ОНТөсөв |
| | | Хөдөөгийн багийн иргэдэд явуулын соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх | 1 удаа 3 сумын 10 баг хүний тоо 2331 | 2 удаа 10 багт хүний тоо-3000 | ОНХСан 11,0 сая төгрөг |
| | 1.6 Үндэсний, сонгодог, орчин үеийн урлагийн төрлүүдийг жигд хөгжүүлж, хүн амд урлаг гоо зүйн боловсрол олгох | Боржигин өв соёлыг сурталчласан"Соёлын өдөр"-ийг Улаанбаатар хотноо зохион явуулах -2024 | 2011 онд зохион байгуулж жүжиг-1, бүрэн хэмжээний концерт-1 | 2024 он Түүхэн жүжиг-1 Бүрэн хэмжээний концерт-1 Боржигин өв соёл үзэсгэл-1 | АЗДТГ, Боржигин чуулга, Номын сан, музей, Соёлын төв ОНХСан 80,0 сая төгрөг |
| | | Засаг даргын нэрэмжит Боржигин | Төрийн болон төрийн | Хүний | ОНХСан 10,0 сая төгрөг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сумдын урлагийн их наадам зохион байгуулах | бус байгууллага ААН хүний тоо- 500 хүн | тоо-800 | |
| | 1.7Соёл урлагийн байгууллагуудын орчин, нөхцөлийг сайжруулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах | Боржигин чуулгын барилгын ажлыг эхлүүлэх | 2021 барилгын ажил эхлэсэн байна. | 2021-2023 Боржигин чуулгын стандартын шаардлага хангасан байртай болсон байна. | УТ 7,1 тэр бум төгрөг |
| | | Боржигин өв музейн их засварын ажил | 2021 онд зураг төсөв хийгдсэн байна | Засварын ажлыг хийсэн байна. | УТ, 328,0 сая төгрөг |
| | | Нийтийн номын сангийн их засварын ажил | 2021 онд зураг төсөв хийгдсэн байна. | Засварын ажлыг хийсэн байна. | УТ, 368,0 сая төгрөг |
| | | Шивээговь суманд Соёлын төв, Баянтал суманд соёл спортын цогцолборын | Баянтал сумын Соёл, спортын цогцолборын | Стандарын байртай болсон байна. | УТ, ОНХСан 5,0 тэр бум |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | барилга барина. | зураг төсөв хийнэ. Шивээговь сумын Соёлын төвийн барилгын зураг төсөв хийгдсэн. | | |
| | 1.7 Соёл урлагийн байгууллагуудын орчин, нөхцөлийг сайжруулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, Аймаг, сумдын номын сангийн номын фондыг нэмэгдүүлнэ.<br><br>Аймгийн музей, сумдын орон нутаг судлалын танхимын үзмэрийн сан хөмрөгийг нэмэгдүүлнэ. | 468 нэр төрлийн ном 1256 ширхэг, 20,0 сая төгрөгийн номоор баяжуулсан. Эх соёл эх үндэс хөтөлбөрийн хүрээнд 22,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан. | Номын тоо – 1500 Үзмэрийн тоо – 15 Тоног төхөөрөмж -20<br><br>Үзмэрийн тоо-1025 | ОАНХСан 110,0 сая төгрөг |
| Зорилт-2 Номын сангийн хууль | 2.1 Стандартад нийцсэн номын сангийн үйлчилгээг уншигчид үзүүлэх, уншлага дэмжсэн олон талт үйл ажиллагаа зохион байгуулах | Хэвлэмэл номын тоо<br>Цахим номын тоо<br>Бэлэг хандивын номын тоо | Хэвлэмэл номын тоо 9861<br>Цахим номын | Хэвлэмэл номын тоо 11500<br>Цахим номын | Номын сангийн төсөв, ОНХСан төсөв 20,0 сая төгрөг, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тоо -34 Бэлэг хандивын номын тоо 237 | тоо -150 Бэлэг хандивын номын тоо 500 | |
| | 2.2 Орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг баяжуулах, орон нутгийн иргэнийг номын сангийн үйлчилгээнд өргөн хамруулах арга хэмжээг | Үзэсгэлэн гаргалт, ном хэвлэл сурталчилах Тоо Хүүхдийн уншлагын дэмжих арга хэмжээ тоо Гэр бүл насанд хүрэгчдийн уншлага дэмжих арга хэмжээ | Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнгээр ном хэвлэл сурталчилсан тоо-17 Хүүхдийн уншлагын дэмжих арга хэмжээ тоо-2 Гэр бүл насанд хүрэгчдийн уншлага дэмжих арга хэмжээ-3 | Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнгийн тоо-45 Хүүхдийн уншлагын дэмжих арга хэмжээ тоо-10 Гэр бүл насанд хүрэгчдийн уншлага дэмжих арга хэмжээ-9 | Нийтийн номын сан, Соёлын төв |
| Зорилт -3 Соёлын өвийг хамгаалах тухай хууль | 3.1 Соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох бүртгэн баримтжуулах, олон нийтэд таниулах, дэмжлэг үзүүлэх, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулах; | СББӨ-ийн өвлөн уламжлагчдыг видео дүрс бичлэгээр баримтжуулсан тоо Олон нийтэд сурталчилан таниулах чиглэлээр хийсэн арга | Баримтжуулсан тоо-5 Олон нийтэд сурталчилан таниулах чиглэлээр хийсэн | СББӨ-ийн өвлөн уламжлагчдыг видео дүрс бичлэгээр баримтжуулсан тоо-30 Олон нийтэд | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэмжээний тоо | арга хэмжээний тоо-2 | сурталчилан таниулах чиглэлээр хийсэн арга хэмжээний тоо-10 | |
| | 3.2 Нутаг дэвсгэртээ соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, шаардлагатай төсөв хөрөнгийг баталж, хяналт тавих; | Үл хөдлөх дурсгалын тоо - 388<br>Гэрээгээр хамгаалж буй дурсгалын тоо- 15 | Үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулсан байна.<br>Үл хөдлөх- 388 | Үл хөдлөх дурсгалын тоо -408 | |
| | 3.3 Соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, Соёлын биет бус өв өвлөн уламжлагчдын шавь сургалт явуулах, алдаршуулан урамшууулах хуульд заасан дэмжлэг үзүүлэх; | Урамшуулсан өвлөн уламжлагч тоо-<br>СББӨ-ийн тоо-<br>ААН-ийг урамшуулсан тоо<br>Шавь сургалтын тоо<br>Өвлөн суралцагчдын тоо | Урамшуулсан өвлөн уламжлагч тоо-3<br>СББӨ-ийн тоо-<br>ААН-ийг урамшуулсан тоо-0<br>Шавь сургалтын тоо - 1<br>Өвлөн суралцагчдын тоо -300 | Урамшуулсан өвлөн уламжлагч тоо-10<br>СББӨ-ийн тоо-<br>ААН-ийг урамшуулсан тоо -3<br>Шавь сургалтын тоо - 3<br>Өвлөн суралцагчдын тоо -340 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Зорилт-4 Музейн тухай хууль | 4.1 Соёлын өвийн талаарх мэдлэг олгох, түүнийг хамгаалах, сурталчлах арга хэмжээг гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлал болон боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлэх | Хүн амын санг хамгаалах, хүн бүр ураг удмаа мэдэж, өрх бүр угийн бичгээ хөтлөх ажлыг хэрэгжүүлэх | Сургалт нөлөөллийн ажлын тоо - 1200 Угийн бичиг хөтөлсөн иргэдийн тоо 700 Угийн бичиг уралдааны тоо-1 | Сургалт нөлөөллийн ажлын тоо - 2000 Угийн бичиг хөтөлсөн иргэдийн тоо 1500 | ОНХСАн 10,0 |
| | | Уралдаан, тэмцээн зохион байгуулах | Уралдаан тэмцээний тоо 20 | 40 | *Байгууллагын төсвөөр* |
| | | Үзмэрийн тоо-1015 Зохион байгуулсан ЭШХ-ын тоо | Үзмэрийн тоо -1015 ЭШХурлын тоо - 1 | Үзмэрийн тоо-1035 Эшх-ийн тоо-4 | *ОНХсан 20,0 сая төгрөг* |
| | | 3D,Vrbox орсон үзмэрийн тоо Шинэчилсэн үзүүллэг дэглэлтийн тоо | 154 1 | 3D үзмэрийн тоо-400 Шинэчилсэн үзүүллэг дэглэлтийн тоо-2 | |
| | 4.3 Соёлын өвийг бүртгэх, цуглуулах соёлын үнэт зүйлийг эрэн сурвалжлах, нээж илрүүлэх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, боловсрол танин мэдэхүйн ажил зохион байгуулах | Соёлын өвийн талаар сургалт зохион байгуулах | Сургалтын тоо -50 | 90 | *Байгууллагын төсвөөр* |
| | | Бүртгэл | СББӨ- | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | мэдээллийн санг бүрдүүлэх,баяжуулах, цахимжуулах | ийн өвлөн уламжлагчдын тоо 360 Үл хөдлөх өвийн тоо 388 Биет өвийн тоо 1015 | 380<br>408<br>1035 | ОНХсан<br>5,0 сая ттөгрөг |
| | 4.3 Соёлын өвийг бүртгэх, цуглуулах соёлын үнэт зүйлийг эрэн сурвалжлах, нээж илрүүлэх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, боловсрол танин мэдэхүйн ажил зохион байгуулах | Музейн боловсролын хөтөлбөр боловсруулах Хамрагдагсадын тоо | Хөтөлбөрийн тоо-1 Боржигин байшин Боловсролын ажилд хамрагдагсадын тоо-3841 | Хөтөлбөрийн тоо-3<br>Хамрагдагсадын тоо - *7545* | Байгууллагын төсвөөр |

1. **Утас, факс: 70543160,99079355**
2. **E-mail хаяг: govisumber@mecs.gov.mn**
3. **Вэб сайт:** www.bolovsrol.gs.gov.mn

Стратеги төлөвлөгөө боловсруулсан: БСУГ-ын ахлах мэргэжилтэн С.Энх-Амгалан
БСУГ-ын СӨБ хариуцсан мэргэжилтэн Б.Энхмэнд
БСУГ-ын статистак хариуцсан мэргэжилтэн А.Баярцэцэг
БСУГ-ын төсөв хариуцсан мэргэжилтэн Н.Одонтуяа
БСУГ-ын соёл хариуцсан мэргэжилтэн Б.Гарасан

Стратеги төлөвлөгөө хянасан: БСУГ-ын дарга А.Зургаанжин

-----оОо-------